

ЭКОЛОГИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020.12.10

Улаанбаатар хот

Экологийн цагдаагийн албанаас энэ онд Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийн хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан.

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн энэ оны “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020 онд хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт батлах тухай” А/65 дугаар тушаалаар батлагдсан бодлогын баримт бичгүүдээс тус албанд хамааралтай 54 баримт бичгийн 85 зүйл, заалтыг хяналтад авч, биелэлт, үр дүнг тооцон холбогдох газарт тогтоосон хугацаанд хүргүүлсэн.

Алба байгуулагдсанаас хойших хугацаанд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаарх мэдээллийг Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны 01/156, 01/610 дугаар албан бичгээр Монгол Улсын Ерөнхий сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдад, 01/163, 01/511 дүгээр албан бичгээр Байгаль орчин, аялал жуулчлалын, 01/164 дүгээр албан бичгээр Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн сайдад тус тус хүргүүлсэн.

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) 2019 оны 10 дугаар сард Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсын жагсаалтад оруулсантай холбогдуулан Монгол Улс энэ оны 04 дүгээр сарын 13-ны өдөр Ази номхон далайн Хамтарсан бүлэгт хоёр дахь явцын тайлангаа хүргүүлснийг мөн оны 05 дугаар сарын 08-12-ны өдрүүдэд хамгаалах, түүнд бэлтгэх вакум хуралд тус албанаас 1 алба хаагч оролцсон.

Дээд шатны байгууллагаас нийт 181 үүрэг, ажлын чиглэл, албан даалгавар, зөвлөмжийг хүлээн авч, биелэлт, үр дүнг тооцон, холбогдох газарт хүргүүлж, алба, хэлтсийн дарга нараас 26 удаагийн үүрэг, ажлын чиглэлийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг тооцсон.

Албаны даргын зөвлөлийн хуралдаанаар 2020 онд хэлэлцүүлэх 19 асуудлын төлөвлөгөөг батлуулан нийт 8 удаагийн хуралдааныг зохион байгуулж, нийт 53 асуудлыг хэлэлцсэний 34,0 хувь нь удирдлага зохион байгуулалтын чиглэлээр, 7,5 хувь нь албаны шалгалтын дүнгийн талаар, 58,5 хувь нь хүний нөөцийн чиглэлээр хэлэлцэн, тодорхой шийдвэрийг гаргаж, үр дүнг тооцсон. Албаны даргын А, Б нийт 109 тушаалыг төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолыг баримтлан, Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн тус албаны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан баталж, Цагдаагийн ерөнхий газрын даргаар хянуулан баталгаажуулж, хэрэгжилтийг тооцсон.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын мөн оны 47 дугаар тушаалаар баталсан загвар, аргачлалын дагуу алба хаагчид төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг улирал бүр гарган батлуулж, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг сар, улирал бүр тооцон ажиллаж байна.

Тус албаны болон аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагчдын албан тушаалын тодорхойлолтын төслүүдийг Төрийн албаны тухай, Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02, 03 дугаар тогтоолд заасан албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах

боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагад нийцүүлэн, боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлэн, Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/153 дугаар тушаалаар батлуулан, алба хаагч нэг бүрд танилцуулж, мөрдөн ажиллаж байна.

Албаны зохион байгуулалтын бүтцийн нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын экологийн асуудал хариуцсан алба хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлж, дүгнэхэд харгалзах үзүүлэлт болгох шалгуур үзүүлэлт, ажил дүгнэх хүснэгтийг энэ оны А/13 дугаар тушаалаар баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газрын Хужирт сум дахь цагдаагийн тасгийн экологийн асуудал хариуцсан байцаагчийн орон тоог Бат-Өлзий сум дахь цагдаагийн хэсэгт шилжүүлэх саналтай ирүүлсэн материалыг албаны даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжих саналын хамт энэ оны 16/259 дүгээр албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын даргад уламжлан хүргүүлж, шийдвэрлүүлсэн.

Тус албаны улирал, хагас жил, жилийн үйл ажиллагааны тайлангийн хурлыг тухай бүр Цагдаагийн ерөнхий газрын 3 дугаар байрны хурлын зааланд алба, аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагч нарыг хамруулан цахимаар зохион байгуулж, дүнг Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/163 дугаар тушаалаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн алба, хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр, төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт”-ийг хэрэгжүүлэх үүрэг бүхий дэд зөвлөлийг албаны даргын А/28 дугаар тушаалаар байгуулж, салбар төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар: Тайлангийн хугацаанд иргэдээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төвд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 3, алба хаагчдаас удирдах албан тушаалтанд нийт 62 санал, хүсэлт, өргөдөл, гомдол ирүүлснийг 100 хувь шийдвэрлэсэн байна.

Архив, бичиг хэргийн үйл ажиллагааны чиглэлээр: Дээд шатны байгууллага болон бусад алба, газар, хэлтэс, төрийн болон төрийн бус байгууллагаас бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр давхардсан тоогоор нийт 2850, үүнээс хугацаатай 479, энгийн 1371 албан бичгийг хүлээн авч, удирдлагын заалт бичүүлэн холбогдох албан тушаалтанд шилжүүлж, алба хаагчдаас төслөөр ирсэн 2288 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн стандарт, Монгол хэлний зөв бичгийн дүрмийн дагуу алдаагүй бичиж, хэвлэмэл хуудсанд буулгаж ажилласан.

Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах, хэрэг бүрдүүлэх, хөтлөгдөж дууссан хэргийг архивд шилжүүлэхэд бэлтгэх явцад баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, байнгын хадгалалтад баримт сонгох болон шилжүүлэхэд бэлтгэх ажлыг зохион байгуулах “Баримт бичиг нягтлан шалгах комисс”-ыг энэ оны А/15 дугаар тушаалаар байгуулж, тус албаны 2020 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг баталж, Цагдаагийн ерөнхий газрын Төв архивд хүргүүлэн хянуулсан.

Хүний нөөцийн чиглэлээр: Монгол Улсын Засгийн газрын энэ оны 03 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын энэ оны А/09 тушаалаар цагдаагийн төв байгууллагын бүтцэд тус албыг байгуулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын мөн оны А/17 дугаар тушаалаар бүтэц, орон тоог баталсантай холбогдуулан хүний нөөцийн нөхөн хангалтыг алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудаас шилжүүлэн буюу зохицуулалт хийн 46, шинээр 12, нийт 58 алба хаагч, ажилтныг томилуулсан.

Тус албаны тусгай мэргэжил, мэргэшил шаардсан зарим албан тушаал дээр нээлттэй сонгон шалгаруулалт зарлан, зарын дагуу 109 иргэн материал ирүүлснээс шаардлага хангасан 40 иргэний материалыг Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлэн, сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, тэнцсэн 13 иргэнийг Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргын Б/03 дугаар

тогтоолоор төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэн, 8 иргэнийг мэргэжилтэн-дадлагажих ажилтнаар томилуулан “Цагдаагийн байгууллагад ажиллах дадлагажих ажилтантай байгуулах гэрээ”-г байгуулан, хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцож, Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуулийн офицер бэлтгэх дамжаанд хамруулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 72 дугаар тогтоолоор баталсан “Цагдаагийн бага, дунд цол олгох, бууруулах, хураан авах, сэргээх журам”-ыг баримтлан энэ онд хугацааны цол шагнагдах 5, офицерын бүрэлдэхүүнд оруулах 6 алба хаагчийн материалыг Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлснээр хугацааны цагдаагийн дэд хурандаа цолоор 1, цагдаагийн хошууч цолоор 2, цагдаагийн ахмад цолоор 2, офицерын бүрэлдэхүүнд оруулж, цагдаагийн дэслэгч цолоор 6, мөн хэлтсийн зөвшөөрлийг үндэслэн цагдаагийн ахлагч цолоор 2, цагдаагийн байгууллагад анх томилж цагдаагийн дэд ахлагч цолоор 4 алба хаагч шагнагдсан.

Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын болон албаны даргын тушаалаар томилогдсон 4 алба хаагчаар цагдаагийн тангараг өргүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг энэ оны А/11, А/27, Б/36 дугаар тушаалаар тус тус батлан, тангараг өргүүлэх ажиллагааг зохион байгуулсан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Шагнал, урамшил олгох /код 925/ журам”-д заасан болзол шаардлага хангасан 11 алба хаагчийг шагнуулах санал, материалыг холбогдох газарт хүргүүлснээр Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хүндэт жуух бичиг”-ээр 1, “Цагдаагийн гавьяа” тэмдгээр 1, Цагдаагийн ерөнхий газрын “Хүндэт жуух”-аар 2, “Албаны төлөө-I,II,III” медалиар 6, Эрүүгийн цагдаагийн албаны “Баярын бичиг”-ээр 1, эхний хагас жилд бусдыгаа хошуучлан ажилласан 7 алба хаагч албаны “Баярын бичиг”-ээр тус тус шагнагдсан.

Шинээр томилогдсон алба хаагчдыг албаны бахархал, үнэт зүйлийн талаар мэдлэг олгох, ажлын арга барилд сургаж дадлагажуулах, цагдаагийн албаны онцлогт дасгаж төлөвшүүлэх зорилгоор 51 алба хаагч, ажилтанд албаны даргын тушаалаар халамжлан хүмүүжүүлэгч нарыг томилж, төлөвлөгөө гарган, үр дүнг тооцсон.

Соён гэгээрүүлэх, албаны сургалтын чиглэлээр: Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны А/07 дугаар тушаалаар баталсан “Албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”-ний хүрээнд тус албанаас энэ онд зохион байгуулах албаны сургалтын төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 18 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр, албаны сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөөг 92 сэдвийн хүрээнд 150 цагийн сургалтыг зохион байгуулахаар тус тус төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажилласан.

Энэ оны байдлаар төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран алба хаагчдын мэдвэл зохих хууль, тогтоомж, тэдгээрийг хөгжүүлэх, дадлагажуулах, бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалтыг нийт 71 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 4072 алба хаагчийг хамруулсан.

Экологийн асуудал хариуцсан алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх цахим сургалт зохион байгуулах Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны “Сургалт зохион байгуулах тухай” А/250 дугаар тушаалаар баталсан хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд сургалтын материалыг видео болон товхимол хэлбэрээр бэлтгэн аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагчдад хүргүүлэн судлуулах ажлыг зохион байгуулж, 60 асуулт бүхий тестийн шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвтэй хамтран гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулсан.

Хууль сахиулах их сургуулийн Цагдаагийн сургуультай хамтран экологийн асуудал хариуцсан алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх зорилгоор “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах арга зүй, эрх зүйн орчин” гарын авлагыг бүтээж, экологийн асуудал хариуцсан алба хаагч нарт тараан, үйл ажиллагаанд нь ашиглуулж байна.

Дотоод хэргийн их сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилд Ахисан шатны боловсролын сургуулийн магистрантурт 2, Цагдаагийн сургуулийн эчнээ 3 жилийн

хөтөлбөрт 1, Ахлагчийн сургуулийн офицер бэлтгэх дамжаанд 9 алба хаагч, ажилтныг хамруулсан.

Бие бүрэлдэхүүний дунд нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлж, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий “Биеийн тамир, спортын хамтлаг”-ийг албаны даргын энэ оны А/07 дугаар тушаалаар байгуулж, тус хамтлагаас энэ онд зохион байгуулах ажил, арга хэмжээний 24 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан, батлуулж энэ онд дартс, 100 буудалт даам, сагсан бөмбөг, ширээний теннис, биллиардын аварга шалгаруулах тэмцээнийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 174 алба хаагчийг хамруулж, амжилттай оролцсон алба хаагчдыг шагнаж урамшуулсан.

Алба хаагчдын тав тухтай байдлыг бүрдүүлэн, гоо зүйн хүмүүжил, экологийн боловсролыг дээшлүүлэх, тэднийг ажиллаж, амьдрах орчиндоо цэцэг тарьж, арчилж ургуулах арга технологид сургах, улмаар байгууллагын орчныг цэцэгжүүлэх замаар эрүүл, аюулгүй, таатай орчинг бүрдүүлэх зорилгоор “Эко орчинг бүрдүүлж, эрүүл амьдарцгаая” цэцэгжүүлэлтийн нэг сарын аян, ажилдаа хандах хандлага, урам зоригийг нэмэгдүүлэх зорилгоор “Дурсамж үлдээсэн мөч”, алба, аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагчдын дунд “Би зөв цэвэр бичигтэн”, “Миний ажлын нэг өдөр” фото зургийн уралдаан, танин мэдэхүйн хөгжөөнт “А-Х-А” тэмцээнийг тус тус зохион байгуулсан.

Үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр: Улсын Ерөнхий прокурорын 2017 оны “Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд прокурор хяналт тавих харьяалал тогтоох тухай” А/67 дугаар тушаалд тус албаны шалгах хэргийн харьяаллыг нэмж тусгуулах саналыг Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны 01/104 дүгээр албан бичгээр Улсын ерөнхий прокурорын газарт хүргүүлснээр Улсын Ерөнхий прокурорын “Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд хяналт тавих харьяаллыг шинэчлэн тогтоох тухай” энэ оны А/33 дугаар тушаалаар “Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24 дүгээр бүлэгт заасан гэмт хэргийг тус албанд харьяалуулах” гэж тусган батлуулсан.

Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар бүлэг /Байгаль орчин амьтан ургамлыг хамгаалах журмын эсрэг/-т заасан зарим төрлийн зөрчлийг Экологийн цагдаагийн албаны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтэс шалган шийдвэрлэх талаар хуулийн төслийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл энэ оны 05 дугаар сарын 20-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар орж дэмжигдсэн.

Тус албаны зарим сум дахь экологийн асуудал хариуцсан байцаагч нарт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлд заасан мөрдөгчийн эрхийг Цагдаагийн ерөнхий газрын даргын А/239 дүгээр тушаалаар олгосонтой холбоотойгоор мөн даргын А/240 дүгээр тушаалаар тухайн байцаагч нараар сум дахь хэсгийн төлөөлөгчийн гүйцэтгэх ажил үүргийг давхар гүйцэтгүүлэхээр чиг үүргийг тогтоосон.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 100, 101, 123, 124, 133, 136, 201, 227, 306, 325, 327, 409, 721, 924/-д тус албаны үйл ажиллагааг зохицуулсан нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах саналыг Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтэст хүргүүлэн, Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/20, А/44, А/45 дугаар тушаалуудаар нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан.

Шинээр батлагдсан, нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомж, эрх зүйн акт 60 ирснийг алба хаагч нэг бүрд танилцуулж, дотоод сүлжээний “Сургалтын цахим сан”-д байршуулан, онлайнаар ашиглах боломжийг бүрдүүлж, дээд шатны байгууллагаас санал авахаар ирүүлсэн 39 журам, төлөвлөгөө, хуулийн төслийг алба хаагчдаар хэлэлцүүлж, гарсан саналыг тусгуулахаар Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалт, Хуулийн хэлтэст тус тус хүргүүлсэн.

Мөн Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн болон аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан 79 байцаагчид Улсын байцаагчийн эрхийг олгуулах

ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах хүсэлтийг 16/234 дүгээр албан бичгээр Улсын ерөнхий прокурорын газрын Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтэст, Улсын байцаагчийн эрхийг олгох хүсэлтийг 16/235 дугаар албан бичгээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт тус тус хүргүүлсэн.

Алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйн чиглэлээр: Алба хаагчдаас баримтлах ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, алба хаагчийн нэр төрийг хамгаалах чиг үүрэг бүхий орон тооны бус “Ёс зүйн зөвлөл”-ийг албаны даргын энэ оны А/22 дугаар тушаалаар байгуулж, тус зөвлөлөөс энэ онд хийж гүйцэтгэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хангаж, тус албаны болон аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагчдын сахилга, ёс зүйн зөрчлийн мэдээг сар бүр нэгтгэн, дүн шинжилгээ хийн ажиллаж байна.

Тус албаны сахилгын /дэлгэрэнгүй, хураангуй/ болон албаны шалгалт, гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон, холбогдсон алба хаагчийн мэдээ, иргэдээс цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн гомдол, мэдээллийн мэдээг сар бүр Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлсэн.

Тус албаны улирал, хагас жил, жилийн сахилгын зөвлөгөөнийг тухай бүр Цагдаагийн ерөнхий газрын 3 дугаар байрны хурлын зааланд алба, аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагч нарыг хамруулан цахимаар зохион байгуулж, дүнг Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлсэн.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын албандаа хандах хандлага, ухамсар, соёлыг дээшлүүлэн гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөж хохирох, сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх алба хаагчдын харилцаа хандлагыг өөрчлөх зорилгоор зохион байгуулж буй “Өнгө нэмцгээе-2020” нөлөөллийн аяны хүрээнд “Хувь хүний төлөвшил”, “Хорт зуршил-Эрүүл бие”, “Хуульч ажиллагаа”, “Харилцаа-хандлага”, “Хариуцлагатай алба хаагч”, “Үлгэрлэл, манлайлал” арга хэмжээнүүдийг зохион байгуулж, дүнг нэгтгэн, нотломжийн хамт хариуцсан албадад хүргүүлсэн.

Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр: Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хоёр дахь үе шатны төлөвлөгөө”-ний хүрээнд 5 зорилтын хүрээнд 30 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр салбар төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг 96,3 хувьтай хангаж, Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлсэн.

Мөн тус албаны хэмжээнд Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, зөвлөлөөс гаргасан жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий 8 хүний бүрэлдэхүүнтэй салбар зөвлөлийг албаны даргын А/25 дугаар тушаалаар байгуулсан.

Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан “Цагдаагийн алба хаагчид хориглох зүйл”, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлд заасан “Хориглох зүйл”-ийг өдөр тутмын ажилдаа баримтлан, сахиж ажиллах тухай 8 заалт бүхий, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр Авлигатай тэмцэх газраас гаргасан “Зөвлөмж”-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 10 дахь заалтыг хангах ажлын хүрээнд 4 заалт бүхий баталгааг нийт 61 алба хаагчаас гаргуулан авч, хяналт тавин ажиллаж байна.

Тус албанд шинээр болон шилжин томилогдсон 58 алба хаагчийн Хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бөглүүлэхэд зөвлөгөө өгч, хянаж, баталгаажуулсан.

Цагдаагийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газрын хамтарсан Төрийн албан хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянах чиг үүргийг хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтнуудыг чадавхжуулах сургалтад 1, Авлигатай тэмцэх газартай хамтран авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх чиглэлээр “Авлигаас урьдчилан сэргийлэх” сэдэвт танхимын сургалтыг зохион байгуулж, 43 алба хаагчийг тус тус хамруулсан. Мөн алба хаагчдад авлигаас урьдчилан сэргийлэх гарын авлага, тараах материалуудыг тус тус өгсөн.

Дотоод аюулгүй байдлын чиглэлээр: Албаны даргын энэ оны 10 дугаар сарын 28-ны өдөр баталсан “Экологийн албаны хэлтсүүдийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн шалгалт явуулах” удирдамжийн дагуу зохион байгуулалтын нэгжүүдийн болон алба хаагчдын үйл ажиллагаанд хэсэгчилсэн шалгалтыг явуулж, дүнг албаны даргад танилцуулж, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, дахин гаргуулахгүй байх чиглэлээр албаны даргын энэ оны 26 дугаартай хугацаатай үүргийг өгч, хэрэгжилтийг ханган ажилласан.

Мөн албаны дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус Ажлын хэсгээс байгууллагын, хүний нөөцийн, алба хаагчийн, санхүүгийн, мэдээллийн, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, агсамжийн, барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хяналт шалгалт хийж, дүнг нэгтгэн албаны даргад танилцуулсан.

Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хэрэгжилтийн талаар

Тус албанаас хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажил, арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллаа.

Нөхцөл байдлын мэдээ: Улсын хэмжээнд энэ оны эхний 11 сард хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 1707 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь урьд оны мөн үеэс бүртгэгдсэн гомдол 946 буюу 1.2 дахин өссөн байна.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг энэ оны эхний 11 сард нийт 611 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 127 хэрэг буюу 26.2 хувиар өссөн үзүүлэлттэй, улсын хэмжээнд бүртгэгдсэн 22506 хэргийн 2.7 хувийг эзэлж хэргийн илрүүлэлт 53.1 хувьтай байна.

Бүртгэгдсэн 611 хэргийн 559 буюу 91.5 хувь нь орон нутагт, 52 буюу 8.5 хувь нь нийслэлд бүртгэгдсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад орон нутагт бүртгэгдсэн хэрэг 112 буюу 25.1 хувиар, нийслэлд бүртгэгдсэн хэрэг 15 буюу 40.5 хувиар тус тус өссөн.

Гэмт хэргийн ангиллаар хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 465 байснаас 587 болж 122 хэргээр буюу 26.2 хувиар, хүнд гэмт хэрэг 19 байснаас 24 болж 5 хэргээр буюу 26.3 хувиар буурсан байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг бүртгэгдсэн зүйлээр нь авч үзвэл, 250 буюу 40.9 хувийг хууль бусаар мод бэлтгэх, 229 буюу 37.5 хувийг хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, 81 буюу 13.3 хувийг хууль бусаар ан агнах, 29 буюу 4.7 хувийг байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх, 17 буюу 2.8 хувийг химийн хорт аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах, 3 буюу 0.5 хувийг байгаль орчныг бохирдуулах, 2 буюу 0.3 хувийг ой хээрийн түймэр тавих гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйл “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал”-ийн 1.8.6.8 дахь хэсэгт цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан зөрчлийг шалгах эрхтэй талаар заасан бөгөөд энэ оны эхний 11 сард Зөрчлийн тухай хуулийн 7.15.8 дахь хэсгээр улсын хэмжээнд 128 зөрчил бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд: Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх чиглэлээр Байгаль орчин, аялал жуулчлалын, Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яам, Нийслэлийн байгаль орчны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Туул голын сав газрын захиргаатай 2020 онд хамтран ажиллах төлөвлөгөө, Монголын байгаль орчны иргэний зөвлөл, Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Монголын бичил уурхайн нэгдсэн “Дээвэр” холбоотой хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Иргэн бүрд байгаль дэлхийгээ шүтэн хамгаалж, байгаль орчинтойгоо зохицон амьдарч ирсэн үндэсний өв уламжлалаа шинжлэх ухаан, инновац, технологийн ололтод тулгуурлан, тогтвортой хөгжлийн төлөөх үзэл баримтлалаар баяжуулан бүх нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан

сэргийлэх, соён гэгээрүүлэх шинэ үеийн нэгдмэл үзэл, төлөвшил, байгаль хамгаалах зөв дадал хандлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2020-2023 онд хэрэгжүүлэх “Байгаль эн тэргүүнд” төслийг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Дээрх төслийн хүрээнд төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, аж, ахуйн нэгж байгууллагуудтай хамтран 8 нөлөөллийн аян, арга хэмжээнүүдийг тус тус зохион байгуулснаар иргэд, олон нийтийн байгаль орчинтой зөв харьцах, хамгаалах мэдлэг ойлголт, боловсролыг дээшлүүлж, зөв үйлдэлд уриалж сэдэлжүүлсэн нийтийн дэмжлэг авсан нийгмийн захиалгат ажил, арга хэмжээ болсон. Зохион байгуулсан нөлөөллийн аян, арга хэмжээнүүдийг дурдвал:

- Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор энэ оны 04-05 дугаар саруудад “Ногоон дуу хоолой” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд 42 удаагийн хяналт, шалгалтаар хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн шинжтэй 119, зөрчлийн шинжтэй 140 үйлдлийг илрүүлэн, 232 зөрчлийг газар дээр нь шийдвэрлэж, 8007 иргэн, хуулийн этгээдэд эрх зүйн туслалцаа, зөвлөгөө өгч, давтан зөрчил гаргасан 90 иргэн, хуулийн этгээдэд хариуцлага тооцож ажилласан;

- Агнуурын загасны нөөц хомстож, устахаас урьдчилан сэргийлэх зорилгоор энэ оны 04-05 дугаар саруудад “Загас хамгаалал-2020” нэгдсэн арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж, 360 удаагийн хяналт шалгалтаар 4957 хүн, 1926 эд зүйл, 2875 тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийж, тусгай хамгаалалттай газарт болон хориглосон хугацаанд загас агнасан 3 гэмт хэрэг, 42 зөрчлийг илрүүлж, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон орлогыг холбогдох журмын дагуу хураан авч ажилласан;

- Иргэд, олон нийтэд хог хаягдлын талаар мэдээлэл өгөх, хөрс, усны бохирдлын эх үүсвэрийг бууруулах чиглэлээр энэ оны 06 дугаар сард “Хогоор бүү хорло” нөлөөллийн аяныг зохион байгуулж, аяны хүрээнд энгийн, аюултай, барилгын болон уул уурхайн хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглах уралдаан 3, аж ахуйн нэгж байгууллагын сайн туршлагыг сурталчлах зорилтод арга хэмжээг тус тус зохион байгуулж, химийн хортой бодис агуулдаг ахуйн хэрэглээний хог хаягдал хүлээн авах 43 цэгүүдийг байгуулсан байна;

- Аялал жуулчлалаас үүдэлтэй хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр энэ оны 07 дугаар сард “Ирлээ, Явлаа, Цэвэр” нөлөөллийн аяныг зохион байгуулж, аяны хүрээнд орон нутагт амрагч, аялагч нарт хариуцлагатай аяллын 10 дүрмийг сурталчлах ажлыг 12 удаа зохион байгуулж, автомашины наалт, тараах материал тус бүр 60.0, хогийн уут, тор 120.0, халаасны тамхины хогийн сав 15.0 ширхгийг тус тус тарааж, зөөврийн 40 ширхэг хогийн савыг шалган нэвтрүүлэх товчоодод байршуулсан.

Мөн төрийн байгууллагуудтай хамтран морьт болон завьт эргүүл ажиллуулж, орон нутаг, нийслэлийн ногоон бүсэд 42 удаагийн хяналт шалгалтаар хүрээлэн байгаа орчны эсрэг 216 гэмт хэрэг, зөрчлийг илрүүлж, зөрчил гаргасан этгээдэд 6.4 сая төгрөгийн торгууль оногдуулсан байна;

- Байгаль орчныг хамгаалах тухай багц хуулийн хэрэгжилтийг хангах, байгалийн нөөц баялаг, биологийн олон янз байдлыг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах, эзэмшихтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, иргэдийн эрх зүйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилгоор “Цэнхэр алт усаа хайрлая”, “Ой модоо хайрлая” нөлөөллийн аяныг энэ оны 09-10 саруудад тус тус зохион байгуулсан.

Аяны хүрээнд “Эх дэлхийдээ хүчилтөрөгч бэлэглэе” уриа дор “Ой модоо хайрлая” өдөрлөгийг зохион байгуулж Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Реалтор төгөл болон Баянзүрх хайрхны ар хормойд 1800 бүйлс, шинэс модыг тарьж, хуурай газрын экосистем, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулж ажилласан.

Ойн нөөцийн хомсдол, усны бохирдлын эх үүсвэр түүний учир шалтгааныг иргэд олон нийтэд таниулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, буруу дадал хандлагыг өөрчлөх, зөв соёлыг төлөвшүүлэх зорилгоор “Norphei Art Gallery”, “Улаанбаатар” аялагч клуб, “I berry brand”-тэй хамтран “Ус ба мод” харьцуулсан фото зургийн үзэсгэлэн, нийслэлийн авто

угаалгын газруудтай хамтран “Усаа хэмнэж, саарал ус ашиглах”, мөн “Эх дэлхийн цэнгэг усаа гамная” арга хэмжээнүүдийг тус тус амжилттай зохион байгуулсан;

- Монгол оронд ховордож буй зэрлэг амьтдын төрөл, зүйлийг иргэд, олон нийтэд таниулах, хайрлан хамгаалах, байгаль орчинд ээлтэй амьдралын хэв маягийг бий болгох, байгаль орчны салбарт мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн актуудыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор “Амьтдаа хайрлая”, агаар орчны бохирдлыг бууруулах, түүний хор аюулыг багасгах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр “Агаар орчны бохирдлын бууруулъя” хэсэгчилсэн арга хэмжээг тус тус зохион байгуулан ажиллаж байна.

Дээрх нөлөөллийн аян, арга хэмжээний хүрээнд иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр Байгаль, зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг “Хүрээлэн” төслийн багтай хамтран “Шонхор эко” нэвтрүүлгийн 2, Эко телевизтэй хамтран “Эко сэргийлэгч” нэвтрүүлгийн 10 дугаарыг тус тус бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэж, телевиз, радиогийн эфирээр 209 удаа /627 минут/, өдөр тутмын сонин, сайтад 262 удаагийн ярилцлага, мэдээ нийтлүүлж, үүрэн телефоны хэрэглэгчдэд давхардсан тоогоор 32 сая зорилтод мессеж илгээсэн.

Мөн байгууллагын цахим хуудсанд 1113 /мэргэжлийн 16 байгууллага, иргэнтэй хамтран видео шторк 49, бүтээлч постер 240 ширхэг/ мэдээ, мэдээлэл байршуулснаар давхардсан тоогоор 41.2 сая хандалт авч, 423.719 хүнд таалагдаж, 260.651 хүн бусдад хуваалцан, 81.595 хүн сэтгэгдэл бичсэн байна.

“Байгаль эн тэргүүнд” төслийн хүрээнд унаган байгалиа хойч үедээ өвлүүлэн, үндэсний бодлого болгон хэрэгжүүлж, ёс заншил, амьдралын хэв маяг, дадал зуршил болгох, экологийн боловсрол олгох зорилгоор “Байгалиа хайрлах бидний үүрэг” ном, “Ногоон хуудас” сэтгүүлийн анхны дугаарыг хэвлүүлэн нийтийн хүртээл болгосон.

“Ус ба уур амьсгалын өөрчлөлт” сэдвийн хүрээнд энэ оны 03 дугаар сарын 22-ны өдөр “Дэлхийн усны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор усны зохистой хэрэглээний чиглэлээр ухуулга, нөлөөллийн зурагт хуудас 32, богино хэмжээний 26 видео бичлэгийг цахим орчинд түгээж, “Витафит групп” ХХК, “Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо”-той хамтран Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, 4 дүгээр хэсэг, уулын зам дагуу иргэдийн амралт зугаалгын газарт 5.0 сая төгрөгийн өртөг бүхий тохижилтын ажил хийж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан.

Говьд ногоон бүс байгуулж, сэргээгдэх эрчим хүч, хөдөө аж ахуй, аялал жуулчлалд суурилсан эдийн засагтай инженерийн суурин байгуулах зорилттой “Шамбала 2056” төслийн багтай хамтран Дорноговь аймгийн Эрдэнэ суманд энэ оны 08 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд “Ногоон” эрчим хүч ашиглая, усаа хайрлая, хоггүй наадъя уриатай “Ногоон наадам-2020” арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.

Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр: Хүрээлэн байгаа орчны эсрэг нийт 303 холбогдогчтой, 7.4 тэрбум төгрөгийн хохиролтой 218 гэмт хэргийг илрүүлж, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан техник, хэрэгсэл 162, алт угаах төхөөрөмж 31, тээрэм 18, чулуу бутлагч 6 ширхэг, хууль бусаар олборлосон 6.4 килограмм алт, жонш 84 тонн, 41.6 килограмм мөнгөн ус, нэн ховор ургамлын үндэс 5.3 тонныг тус тус хураан авч битүүмжлэн ажилласан.

Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр энэ онд нийт давхардсан тоогоор 90 алба хаагч 11 аймгийн нутаг дэвсгэрт 36 удаагийн хяналт шалгалтаар ажиллаж гэмт хэргийн шинжтэй 85 үйлдлийг илрүүлсэн. Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах “ASAP” санд эрэн сурвалжлагдаж байсан оргодол 4, гэмт хэрэгт сэрдэгдсэн хүн 61, эд зүйл 19 тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоож, холбогдох газар, хэлтэст хүлээлгэн өгсөн.

Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, байгаль экологид учрах хохирлыг бууруулах чиглэлээр 10 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулсан. Зохион байгуулсан зарим ажил, арга хэмжээг дурдвал:

- Байгаль орчин, аялал, жуулчлал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдэгдсэн талбайн хэмжээг тогтоон, нөхөн сэргээлтийг холбогдох этгээдээр зохих журмын дагуу хийлгүүлэх зорилгоор улсын

хэмжээнд “Нөхөн сэргээлт-2020” ерөнхий арга хэмжээг зохион байгуулж, улсын хэмжээнд эвдэгдсэн 30.790 га талбайг тогтоосноос 3148 га талбайд нөхөн сэргээлт хийлгүүлж, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийн илрүүлэлт урьд оны мөн үеэс 69.5 хувиар өссөн;

- Ой, хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, шуурхай шалгаж шийдвэрлэх зорилгоор “Ой хээрийн түймэр” хэсэгчилсэн арга хэмжээг энэ оны 04-05 дугаар саруудад хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулж, орон нутгийн Онцгой байдлын хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Тусгай хамгаалалтын газар болон нутгийн иргэдийн хамт нийт 39 удаагийн эргүүл, шалгалтыг 1019 хүн, хүчтэйгээр зохион байгуулж, иргэд, олон нийтэд 15450 санамж, сэрэмжлүүлэг, ухуулгын хуудас бэлтгэн тарааж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх 8 самбарыг байршуулсан ажилласнаар энэ төрлийн гэмт хэргийн гаралт 59.2 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна;

Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны “Цагдаа, дотоодын цэргийн бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдлын хоёрдугаар зэрэгт шилжүүлэн ажиллуулах тухай” А/52 дугаар тушаал, өгсөн үүргийг хэрэгжүүлж, алба хаагчдыг Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны даргын баталсан “Сар шинэ-2020” нэгдсэн арга хэмжээний хүрээнд алба хаагчид Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт эргүүлийн үүрэг гүйцэтгэж ажилласан.

Тулгар төрийн 2229, Их Монгол Улсын 814, Ардын хувьсгалын 99 жилийн ой, Үндэсний их баяр наадмын өдрүүдэд тус албаны алба хаагчид Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газрын хоёрдугаар хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт нийтийн хэв журам сахиулах чиглэлээр эргүүлийн үүрэг гүйцэтгэж, зөрчил дутагдалгүй ажилласан.

Дэлхийн олон улсад шинэ төрлийн коронавирусын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан хүн амыг болзошгүй аюулт өвчнөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан.

Мэдээлэл судалгааны чиглэлээр: Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас нэгтгэн гаргасан статистик мэдээн дээр тулгуурлан хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын танилцуулга, цагаан мэдээг сар бүр өссөн дүнгээр нэгтгэн гаргаж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Мэдээллийн технологи, холбооны чиглэлээр: Алба хаагчдын албаны компьютерт шинээр үйлдлийн систем суулгасан 29, domain тохиргоо 91, outlook mail тохиргоо 120, линк тохиргоо 161, принтер тохиргоо 101, программ суулгасан 116, хурууны хээ бүртгэл 58, сүлжээний холболт, гэмтэл засварласан 70 нийт 746 удаагийн гэмтэл засвар, тохиргоог хийн хэвийн ажиллагаанд оруулсан.

Гурав. Санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний талаар

Тус албаны Төрийн сангийн харилцахын 1000900012106, нэмэлт санхүүжилтийн 100900012480 дугаар данснуудыг нээлгэж, дансны хуулга харах эрхийг авсан. Тус албанд энэ онд 1,4 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас алба хаагчдын цалин хөлс, урамшуулал 749,6 сая, бусад урсгал зардал 156,0 сая төгрөгийн бараа үйлчилгээний худалдан авалтыг хийсэн.

Энэ оны батлагдсан төсвөөс хэмнэгдсэн 47,5 сая төгрөгийг Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын дагуу зардлын бүлэг хооронд шилжүүлэх саналыг өгч, шийдвэрлүүлэн зарцуулах эрхийг нээлгүүлэн үйл ажиллагаандаа зарцуулж байна.

Энэ оны төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын тайланг гарган Шилэн дансны нэгдсэн портал системийн <http://www.shilendans.gov.mn> болон тус албаны ecological.police.gov.mn цахим хуудаснуудад тус тус байршуулсан. Мөн тус албаны улирал бүрийн санхүүгийн тайланг

Санхүү, аж ахуйн албанд, шийтгэлийн хуудас /маягт-2/-ны тайланг Нийслэлийн цагдаагийн удирдах газарт тус тус хүргүүлсэн.

Алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр: Алба хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмжийг шийдвэрлэн өгч, дэмжлэг үзүүлэх хүсэлтийг Санхүү, аж ахуйн албанд хүргүүлж, шийдвэрлүүлсэн.

Экологийн асуудал хариуцсан алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр монгол хэл дээр орчуулсан цэстэй газрын зургийн GPS программыг судалж, Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулснаар “Navi market” ХХК-иас 30 ширхэг GPS программыг худалдан авсан.

Алба хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр 2020 онд зохион байгуулах ажил, арга хэмжээний төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:

- Алба хаагчдын амьдрал ахуйтай танилцаж, нийгмийн баталгааг хангах, ажил, үүрэг гүйцэтгэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх нийгмийн асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэх зорилгоор 36 алба хаагчийн ар гэртэй танилцаж, тэдний санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх ажил, арга хэмжээг зохион байгуулсан;

Алба хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр алба хаагчдаас 13 асуумж бүхий судалгааг нэг бүрчлэн авч, дүнг нэгтгэхэд 3 алба хаагч нь ипотекийн зээл, 13 алба хаагч түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасантай холбогдуулан ипотекийн зээлд 5, түрээсийн орон сууцны хөтөлбөрт 5 алба хаагчийг хамруулах хүсэлтийг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн алба, Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст тус тус хүргүүлсэн.

Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр: Тус албанаас “Эрүүл цагдаа” хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулсан ажил, арга хэмжээний биелэлтийг 92,5 хувьтай дүгнэж, дүнг Санхүү, аж ахуйн албанд хүргүүлсэн. Үүнд:

- Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах ажлын хүрээнд “Хорт хавраас сэргийлье”, “Нурууны суултаас урьдчилан сэргийлэх”, “Гепатитын В, С вирусийн халдвар”, “Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх”, “Эрүүл зөв хооллолт” зэрэг нийт 9 сургалтын материалыг бэлтгэн “ЭКО-АЛБАНЫ СУРГАЛТ” фейсбүүк хаалттай группт байршуулж, цахим сургалтыг зохион байгуулсан;

- Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, дархлааг дэмжих зорилгоор “Нэг сэтгэл, нэг хамт олон” аяныг энэ оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс 1 сарын хугацаатай зохион байгуулж, хуваарийн дагуу 20 удаа давхардсан тоогоор 246 алба хаагчид өдөр бүр илчлэг халуун аарц, чацаргана, аньсны шүүсээр үйлчлэн, витаминжуулалтын аяныг өрнүүлэн алба хаагчдын дархлааг сайжруулах, өвчлөлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор вакус, С, Е витамин тараан өгч ажилласан;

- Эрүүл, аюулгүй, таатай орчныг бүрдүүлэх зорилгоор “Эко орчинг бүрдүүлж, эрүүл амьдарцгаая” цэцэгжүүлэх аян, мөн эрүүл, зөв хооллолтын өдөрлөгийг 2 удаа зохион байгуулсан;

- Алба хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо хийлгэх зорилгоор Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгтэй хамтарч энэ оны 04 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд 31 алба хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулснаар 4 алба хаагч өдрийн эмчилгээ хийлгэж, 2 алба хаагч хэвтэн эмчлүүлсэн;

- Алба хаагчдын дунд “Цэвэр агаар эм” уриа дор эрүүл аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх, хамт олны дунд нэгдмэл, эвсэг уур амьсгалыг бий болгох зорилгоор энэ оны 10 дугаар сард Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэр Дугуй цагаан, Баруун ширээтийн замаар алхалт хийсэн;

- Нийслэлийн цагдаагийн удирдах газрын сэтгэл зүйчдийн багтай хамтран алба хаагчдаас сэтгэл зүйн сорил авч, сорилын дүгнэлтэд тулгуурлан 17 алба хаагчид ганцаарчилсан зөвлөгөө өгч ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн баталсан “Хууль зүй, дотоод хэргийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр”-ийн хүрээнд 6 заалттай салбар төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган дүнг Санхүү, аж ахуйн албанд хүргүүлсэн. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн дагуу албан үүргээ гүйцэтгэж байхдаа гэмтэж бэртсэн, осолд өртөж хохирсон, амь насаа алдсан цагдаагийн алба хаагчдыг судлан бүртгэх, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг албаны даргын энэ оны А/09, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий орон тооны бус “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл”-ийг А/21, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтныг А/20 дугаар тушаалаар тус тус томилсон;

- Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр, аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийн талаар 2 төрлийн сургалтын материал бэлтгэн “ЭКО-АЛБАНЫ СУРГАЛТ” фейсбүүк хаалттай групп, дотоод сүлжээний дундын цахим “Сургалтын сан”-д тус тус байршуулан, алба хаагчдыг онлайнаар бие даан суралцах нөхцөлийг бүрдүүлсэн;

- Албан томилолтоор ажиллаж байх үедээ биедээ гэмтэл авсан 1 алба хаагчийн гэнэтийн ослын даатгалын нөхөн олговрыг олгуулахаар “Практикал” даатгалд холбогдох материалыг бүрдүүлэн өгч, нөхөн олговрыг олгуулсан.

Дөрөв. Дүгнэлт

Тус алба нь энэ онд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиг үүргээ амжилттай хэрэгжүүлж, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаа.

Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны 14 журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг холбогдох нэгжид хүргүүлэн, шийдвэрлүүлж, Эрүүгийн цагдаагийн, Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн алба хаагчдын гэмт хэрэг, зөрчил шалгах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль, Улсын Ерөнхий прокурорын 2017 оны “Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд прокурор хяналт тавих харьяалал тогтоох тухай” А/67 дугаар тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг холбогдох газарт уламжлан, шат дараатай шийдвэрлүүлэн ажиллаж байна.

“Байгаль эн тэргүүнд” төслийн хүрээнд зохион байгуулсан ажил, арга хэмжээнүүд давхардсан тоогоор 41.2 сая хүнд хүрч иргэд, олон нийтийн байгаль орчинтой зөв харьцах, хамгаалах мэдлэг ойлголт, боловсролыг дээшлүүлж, зөв үйлдэлд уриалж сэдэлжүүлсэн, нийтийн дэмжлэг авсан нийгмийн захиалгат ажил, арга хэмжээ болсон.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлын хүрээнд хяналт шалгалтыг эрчимжүүлэн ажилласнаар энэ оны эхний 11 сарын байдлаар хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг нийт 611 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 127 буюу 26,2 хувиар, хэргийн илрүүлэлт 5,0 хувиар тус тус өссөн эерэг үзүүлэлтэй байна.

Тав. Цаашид хэрэгжүүлэх ажлын талаар

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/110 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг 2020-2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний”-ий хэрэгжилтийг эрчимжүүлэх;

- Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2021 онд дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн ерөнхий газрын болон албаны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлтийг ахиулах;

- Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, иргэдийн эрх зүйн

боловсролыг дээшлүүлэх зорилгоор нутаг дэвсгэрийн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, холбогдох мэргэжлийн болон хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран мэдээлэл сурталчилгаа, ухуулга, нөлөөллийн арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах;

- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8000 га талбайд нөхөн сэргээлт хийх ажил тусгагдсантай холбогдуулан “Нөхөн сэргээлт-2021” ерөнхий арга хэмжээг зохион байгуулах.

ЭКОЛОГИЙН ЦАГДААГИЙН АЛБА